



ТӨВ АЙМАГ
СЭРГЭЛЭН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

41091 Төв аймаг, Сэргэлэн сум, Эрдэнэ-Уул баг,
Утас: 9815 9996, Вэбсайт: www.sergelen.to.gov.mn

2024.07.23 № 03/118
танай _____-ны № _____-т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/245 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо нь Сэргэлэн сумын хатуу хучилттай авто зам барих ажил гүйцэтгэгч сонгон шалгаруулах (ТӨАСЭСЗДТГ/20240101062) ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг цахимаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 32 дугаар зүйлийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 11:20 цаг хүртэл үнийн саналын урилга хүлээн авсан оролцогчдоос 9 аж ахуйн нэгж материал ирүүлсэн. Үүнд:

- 1 дүгээр “33Б” ХХК: 5,999,926,935 төгрөг
- 2 дугаар “Амьюс” ХХК: 5,956,605,667 төгрөг
- 3 дугаар “МАЗ” ХХК: 5,823,538,890 төгрөг
- 4 дүгээр “Трүйрөүд” ХХК: 5,816,975,512 төгрөг
- 5 дугаар “Голдендрийм” ХХК: 5,802,427,150 төгрөг
- 6 дугаар “Жинчингранд” ХХК: 5,775,553,517 төгрөг
- 7 дугаар “Огторгуйн бүтээл” ХХК: 5,743,356,226 төгрөг
- 8 дугаар “Борхойн зам” ХХК: 5,692,161,295 төгрөгийн цахим үнийн санал тус тус ирлүүлснээс;

ТББ-т ирүүлсэн материалыг ТШӨХүснэгт болон ТШЗ-ний дагуу хянан үзээд;

Уг тендерт ТБОНӨХБАҮХАТХуулийн 27,5 дагуу “Жинчингранд” ХХК нь үнэлгээний хорооны гишүүдийн 100 хувийн шийдвэрийн дагуу шалгаруулж ТБОНӨХБАҮХАТХуулийн 28.1.1 дэх заалтыг баримтлан гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн. Гэвч 33Б ХХК гомдол гаргаж Сангийн яамны 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 03/5587 тоот мэдэгдэлд 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр түдгэлзүүлэх тухай албан мэдэгдэл Сангийн яамны хууль, эрх зүйн газрын худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсээс ирсэн.

Гомдол хянасан тухай 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 03/5587 тоот мэдэгдэл ирсэн. Тус мэдэгдэлд Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дугаар зүйлийн 59.10.2 дахь заалтад үндэслэн мэдэгдсэн.

Иймд ТБОНӨХБАҮХАТХуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын 5.14-т зааснаар тендерийн хүчинтэй хугацааг ажлын 15 хоногоор сунгасан болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.ЛХАГВАДУЛАМ

